



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

**ЖАВХЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
АРДЧИЛСАН НАМД**

2024. 08. 06 № ГНАГ-2024/13-ШТА-НА-24  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Жавхланта сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Жавхланта сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль,

холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгосон.

### Дүгнэлт

Ардчилсан намын Жавхлант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Жавхлант сумын Ардчилсан намын хорооны мөрийн хөтөлбөр ( .....<sup>10</sup>..... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Жавхлант сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЖАВХЛАНТ СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ СОНГУУЛЬД  
ОРОЛЦОХ АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



**ИРГЭНЭЭ ДЭМЖИЖ, ЭХ НУТГАА  
ХӨГЖҮҮЛЬЕ.**

***Эрхэм зорилго: Сум орон нутгийн эдийн засаг эрчимтэй хөгжсөн, сайн засаглал, шударга ёс тогтсон, хүн бүр ажил орлоготой, эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах хүнлэг ардчилсан нийгмийг тогтооход оршино.***

2024 он



# ТОВЧ УТГА

## НЭГ.ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ, НИЙГМИЙН ХӨГЖИЛ

- 1.1.Гэр бүл, хүүхэд
- 1.2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэд
- 1.3.Залуучууд, ахмад, эмэгтэйчүүдийн нийгмийн хамгаалал
- 1.4.Боловсрол
- 1.5.Эрүүл мэнд
- 1.6.Соёл урлаг

## ХОЁР.ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

- 2.1.Хөдөлмөр эрхлэлт
- 2.2.Газар тариалан
- 2.3.Мал аж ахуй
- 2.4.Барилга, дэд бүтэц
- 2.5.Орон сууц
- 2.6.Эрчим хүч
- 2.7.Төсөв, санхүү, татварын бодлого
- 2.8.Жижиг дунд бизнес, бизнесийн дархлаа
- 2.9.Худалдаа үйлчилгээ

## ГУРАВ.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ИРГЭДИЙН ОРОЛЦОО

- 4.1.Төрийн албан хаагчид, төрийн үйлчилгээний шуурхай байдал

## ДӨРӨВ.АЮУЛГҮЙ ТАЙВАН ОРЧИН

## ТАВ.БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЧЛАЛ

## ЗУРГАА.ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ШУДРАГА ЁС

## НЭГ. ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ, НИЙГМИЙН ХӨГЖИЛ



### 1.1. Гэр бүл, хүүхэд:

1.1.1. Өрхийн 0-5 насны хүүхдийн тусламж, үйлчилгээг чанаржуулах, хүртээмжийг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.1.2. Хүүхдийг цахим халдлагаас хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр санал санаачилга гаргана.

1.1.3. Гэр бүл, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх хамгаалах талаар шаардлагатай зөвлөгөө сургалт, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулна.

1.1.4. Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ авна.

1.1.5. Хүүхэд бүрийг хөгжүүлж, өөртөө итгэлтэй, Монгол орныхоо байгаль, түүх үндэсний хэл соёл, уламжлалаар бахархдаг хүмүүжил олгох “Зөв Монгол хүүхэд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.1.6. Хүүхэд, залуучуудыг хөгжүүлэх “ЖАВХЛАНТ STEAM” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. /Шинжлэх ухаан, технологи, инженер, урлаг, математик хөгжил/

1.1.7. Гэр бүлийн гишүүн бүрд гэр бүлийн боловсрол олгох “Монгол гэр бүл” боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

### 1.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд:

1.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бусдын адил бизнес эрхлэх, сурч, хөдөлмөрлөх, бие даан амьдрахад нь туслах, сэргээн засах, нийгмийн харилцаанд ороход туслан дэмжих зэргээр тэдний хэрэгцээнд нийцсэн олон талт мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ.

1.2.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн тогтмол орлого олох нөхцөл бололцоог хангаж, бүх талын туслалцаа үзүүлнэ.

1.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэн нийгмийн амьдралд тэгш оролцох боломжийг нэмэгдүүлсэн үйлчилгээнд хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэхийг бодлогоор дэмжинэ.

### 1.3. Залуучууд, ахмад, эмэгтэйчүүдийн нийгмийн хамгаалал:

1.3.1. Залуучуудын хөгжлийн “Community center” байгуулж, чөлөөт цагаа өнгөрөөх, хамтдаа хөгжих, суралцах орчныг бүрдүүлнэ.

1.3.2. Сумандаа ажиллаж буй залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.3.3. Ахмадын эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.

### 1.4. Боловсрол:

1.4.1. Ахлах ангийн сурагчдыг ажил хөдөлмөрт бэлтгэх зорилгоор “Зуны хөтөлбөр”-ийг зохион байгуулна.



1.4.2. Ард иргэд, аж ахуйн нэгж, компаниуд, хандивлагчдын идэвхтэй оролцоо, дэмжлэгийг хангах замаар боловсролыг дэмжих “Орон нутгийн сан”-г байгуулж, нээлттэй, олон нийтийн хяналттай, ил тод, үр дүнтэй зарцуулж хэвшүүлнэ.

1.4.3. Багшийг хөгжүүлэх “Сайн багш-Хөгжсөн сурагч” сумын дэд хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

1.4.4. Суманд зайлшгүй шаардлагатай мэргэжлээр суралцаж буй 2-оос доошгүй шилдэг сурагчдыг жил бүр оюутны тэтгэлэгт хамруулах талаар холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.

1.4.5. Хүүхэд харах үйлчилгээг орон нутгийн боломжид тулгуурлан цэцэрлэгийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

1.4.6. Хөдөөгийн багийн цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлж, алслагдсан хүүхдүүдэд хүрч ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

1.4.7. Сургууль, цэцэрлэг болон дотуур байрны орчин, нөхцөлийг сайжруулах төслийг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

### **1.5. Эрүүл мэнд:**

1.5.1. Иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөлийг бууруулах талаар эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллана.

1.5.2. Сумын эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээг түргэн шуурхай чанар хүртээмжтэй, ил тод, ёс зүйтэй, иргэддээ ээлтэй болгоно.

1.5.3. Хорт хавдрын шалтгаант нас баралтыг бууруулж, эрт илрүүлэлт, оношилгоо, эмчилгээний чанарыг сайжруулах зорилт тавьж ажиллана.

1.5.4. Иргэдийг насны бүлэгт нь тохирсон урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулах ажлыг зохион байгуулна.

1.5.5. Яаралтай түргэн тусламжийн үйлчилгээний зохион байгуулалтыг шинэчилж, материаллаг баазыг бэхжүүлэх, үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг оновчтой зохион байгуулж, үр дүнг тооцдог болгоход онцгой анхаарч ажиллана.

1.5.6. Сумын хэмжээнд мэргэжлийн эмч, эмнэлгийн ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бололцоогоор хангаж ажиллана.

1.5.7. Хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд эрүүл, аюулгүй, ээлтэй орчныг бүрдүүлж, эрүүл амьдралын зөв дадал, хэвшлийг төлөвшүүлэн, эрт илрүүлгийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

1.5.8. Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийн чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, нэн шаардлагатай тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэлтэй болгоно.

### **1.6. Соёл урлаг, спорт:**

1.6.1. Уламжлалт өв соёлоо бодлогоор дэмжин соёлын өвийг олны хүртээл болгох ажлыг эхлүүлнэ.

1.6.2. Сумын соёлын биет ба биет бус өвийг хадгалан хамгаалах, сэргээн засварлах, түүнийг хамгаалан цуглуулагч, тээн уламжлагч нарыг сурталчлан дэмжинэ.

1.6.3. Түүх, соёлын дурсгалт газрын бүртгэл, хамгаалалтыг сайжруулна.

1.6.4. Ардын авьяастан, авьяаслаг сурагчид болон урлагийн холбоодын үүсгэл, санаачилгыг дэмжинэ.

1.6.5. Үндэсний өв соёл, зан заншлыг сэргээн хөгжүүлэх, сурталчилж өвлүүлэх зорилгоор сумын үндэстэн ястны язгуур урлагийн наадмыг зохион байгуулж, ардын авьяастнуудыг тодруулна.

1.6.6. Түүх, соёлын агуулга бүхий контентыг хөгжүүлж, үзэгчдэд хүртээл болгох ажлыг зохион байгуулна.

1.6.7. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх чиглэлээр хүүхэд залуучуудын спорт цогцолборыг ашиглалтад оруулна.

1.6.8. Спортын арга хэмжээ, фестиваль, уралдаан, тэмцээнийг зохион байгуулах, оролцоход бодлогоор дэмжиж, хамтран ажиллана.

1.6.9. Эрүүл, идэвхтэй аж төрөх талаар сургалт, сурталчилгааг сайжруулж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.

1.6.10. Соёлын төвийн нэмэлт орлого олох боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.

## **ХОЁР.ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ**

### **2.1. Хөдөлмөр эрхлэлт:**

2.1.1. Сумын жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж, үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг борлуулах талаар хувийн хэвшилтэй хамтран ажиллана.

2.1.2. Баялаг бүтээгчдээ дэмжиж, сумын иргэдийнхээ орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.1.3. “Өрх бүр баялаг бүтээгч” дэд хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

2.1.4. Малын гаралтай түүхий эдийг боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хөдөө аж ахуйг хөгжүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ.

### **2.2. Газар тариалан:**

2.2.1. Усалгаатай тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн ус, эрчим хүчний хэмнэлттэй, байгальд ээлтэй техник, технологийн хангамжийг сайжруулж, нэгжээс авах ургацыг дээшлүүлнэ.

2.2.2. Шинэ ургацын ногооны нэр төрөл, хангамжийг сайжруулах зорилгоор хүлэмжийн аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжиж, дуслын усалгаанд шаардлагатай нар, салхины сэргээгдэх эх үүсвэрээр хангах төсөл хэрэгжүүлнэ.

2.2.3. Услалтын системийн менежментийг боловсронгуй болгож, тариалан эрхлэгч, хүнсний ногоо тариалагчдыг бодлогоор дэмжиж ажиллана.



2.2.4. Өндөр ашиг шимтэй эрчимжсэн мал аж ахуйг газар тариалангийн үйлдвэрлэлтэй хослуулан хөгжүүлнэ.

2.2.5. Ургамал хамгаалалтын орчин үеийн арга технологийг иж бүрэн хэрэгжүүлж, тариалангийн талбайн хөрсийг элэгдэл, хортон шавжаас хамгаалах, үйлдвэрлэлийн зохистой дадлыг нэвтрүүлэх боломжийг бүрдүүлнэ.

2.2.6. Дөрвөн улирлын хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийг бодлогоор дэмжиж, хамтран ажиллана.

2.2.7. Газар тариалангийн үйлдвэрлэлийн мэргэжлийн ажиллах хүчний хангамж, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.2.8. Бүх нийтийн хүнсний боловсролыг дээшлүүлэх, хоол хүнс, шим тэжээлийн чанар, аюулгүй байдлыг эрүүл амьдралын зан үйл, хэвшилтэй нягт уялдуулах чиглэлээр сумын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

2.2.9. Хүн амын гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний сумын хэрэгцээг чанартай хүнсээр хангаж, хүнсний нийлүүлэлтийн сүлжээг бий болгох замаар найдвартай хүнс нийлүүлэгч сум болох бодлого баримтална.

2.2.10. Малчдын мал маллах дундын бэлчээрийг баталгаажуулж, ашиглалтын хариуцлагыг нэмэгдүүлж, малчдын эрх ашгийг хамгаална.

2.2.11. Суурин болон хагас суурин маллагаатай эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх зохицуулалтын бодлогыг дэмжин ажиллана.

2.2.12. Тариалангийн талбайд ойн зурвас байгуулж, хөрсний элэгдэл, малын хөлөөс хамгаална.

2.2.13. Газар тариалангийн үйлдвэрлэлд техникийн шинэчлэл хийж, баталгаат сортын үрийн хангамж, ургамал хөрс хамгаалалт, услалтын систем барих зэрэг агро техникийн цогц арга хэмжээг дэмжинэ.

### **2.3. Мал аж ахуй:**

2.3.1. Малын эмч нарын ур чадварыг дэмжих замаар нэгж малд ногдох мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулна.

2.3.2. Малыг тооноос илүү чанарт шилжүүлж, малын төрлийг зохистой харьцаанд хүргэж, эдийн засгийн ашигтай, технологид суурилсан мал аж ахуйг хөгжүүлнэ.

2.3.3. Сумын хэмжээнд малын үүлдэр омог, угшлыг баталгаажуулж, төрөлжсөн хэлбэрээр өсгөж үржүүлнэ.

2.3.4. Мал аж ахуйн эрүүл бүсийг баталгаажуулж, мал эмнэлгийн үйлчилгээний хүртээмжийг чанартай болгож, хяналтыг сайжруулна.

2.3.5. Малаас гарч буй түүхий эд болох арьс шир, ноос ноолуурыг боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчдийг бодлогоор дэмжиж ажиллана.

### **2.4. Барилга, дэд бүтэц:**

2.4.1. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг нийт салбарын хөгжилтэй уялдуулан нэгдмэл болгох хөтөлбөр хэрэгжүүлнэ.



2.4.2. Гэр хорооллын дэд бүтцийг шийдэж, айл бүрийг хашаандаа сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Таны хашаа” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.4.3. Жавхлант сумын аялал жуулчлалын зориулалттай танилцуулга гаргана.

2.4.4. Гудамж, нийтийн эзэмшлийн талбай, авто замуудыг засварлах, шинээр байгуулах ажлыг шат дараатай зохион байгуулна.

2.4.5. Сумын төвийн хүн амыг эрүүл ахуй, чанарын шаардлагад нийцсэн усаар хангах, дэд бүтцийг сайжруулах асуудлыг шийдвэрлэнэ.

2.4.6. Халаалтын нэгдсэн төвд төр, төсвийн байгууллагууд, ойролцоох айл өрхүүдийг холбох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

2.4.7. Бэлчээрийн даацыг тохируулах замаар алсын бэлчээрийг усжуулах, шинээр худаг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.

2.4.8. Замын үерийн хамгаалалтын далан, үер усанд идэгдсэн зам, талбайн засварыг ажлыг тогтмол хийнэ.

2.4.9. Сумын төвийн уурын зуух болон ахуйн үйлчилгээг засварлаж, тохижуулна.

## **2.5. Орон сууц:**

2.5.1. Шинээр болон шилжин ирж ажиллаж буй төрийн албан хаагчдыг дэмжих зорилгоор түр амьдрах байр /төрийн албан хаагчдын орон сууц/ барих ажлыг хувийн хэвшилтэй хамтран зохион байгуулна.

## **2.6. Эрчим хүч:**

2.6.1. Суманд халаалтын нэгдсэн төв барих ажлыг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд шийдвэрлэнэ.

2.6.2. “Шинэ зууны малчин” хөтөлбөр хэрэгжүүлж, малчин өрхүүдийг хүчин чадал өндөртэй цахилгаан хэрэгсэл ашиглах боломжоор хангах бодлогыг хэрэгжүүлнэ.

## **2.7. Төсөв, санхүү, татварын бодлого:**

2.7.1. Орон нутгийн төсвийн зардлыг ач холбогдол, үр өгөөжөөр нь эрэмбэлэх зарчимд шилжиж, үр ашигтай хуваарилалтын бодлого хэрэгжүүлнэ.

2.7.2. Орон нутгийн үйлдвэрлэгчдийнхээ бүтээгдэхүүнийг худалдан авах хандлагыг бий болгож, мөнгөн гүйлгээг нутагтаа авч үлдэх бодлого баримтална.

2.7.3. Хуримтлалыг бий болгох сургалт мэдээллийн бодлогыг хэрэгжүүлж, иргэдийн банкин дахь хадгаламжийн хэмжээг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

2.7.4. Татварын байцаагч, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын харилцан уялдаа холбоог сайжруулан, татварын зөвлөгөө өгдөг, хуулийг дээдэлдэг, бизнесийг дэмждэг чиглэлийг баримтална.

2.7.5. Иргэн, аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагааг дэмжсэн өгөөжтэй санхүүгийн зуучлалыг хөгжүүлэхэд бодлогоор дэмжиж ажиллана.

## **2.8. Жижиг, дунд бизнес, бизнесийн дархлаа:**

2.8.1. Жижиг дунд бизнесийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, гарцыг нэмэгдүүлэхэд шаардлагатай мэдээллийн сан үүсгэж, гарааны бизнесийг бодлогоор дэмжин, бүтээгдэхүүн үйлчилгээг мэдээллийн санд байршуулна.

2.8.2. Өрхийн болон жижиг, дунд үйлдвэрлэл, баялаг бүтээгчдийг дэмжин орон нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бодлогоор дэмжин ажиллана.

2.8.3. Төрийн зүгээс бизнес эрхлэгчдэд үзүүлж буй хүнд суртал, дарамтыг арилгаж, татвар төлөгч аж ахуй нэгжүүддээ үйлчилдэг, зөвлөдөг болгоно.

2.8.4. Аялал жуулчлалын салбарыг орон нутгийн оролцоотойгоор хөгжүүлэх ажлыг зохион байгуулж, хувийн хэвшлийг дэмжиж ажиллана.

## **2.9. Худалдаа үйлчилгээ:**

2.9.1. Хүн амын хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүний сумын хэрэгцээг аюулгүй, чанартай хүнсээр хүртээмжтэй, тогтвортой хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.9.2. Хүн амын хүнсний чанар, шим тэжээлийг сайжруулж, тэнцвэртэй, эрүүл хооллолтын зохистой дадлыг хэвшүүлнэ.

2.9.3. Байгалийн болон бэлчээрийн мал аж ахуйн гаралтай органик хүнс, хүнсний нэмэлт тэжээлийн үйлдвэрлэлийг дэмжинэ.

2.9.4. Хүнсний гол хэрэгцээ болох мах, ногооны зориулалтын зоорийг барих, мах, хүнсний ногооны хадгалалтыг сайжруулах асуудлыг хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

2.9.5. Жимс, жимсгэнэ, нарийн ногоо тариалах болон хүлэмжийн газар олгох, ашиглахад уян хатан бодлого баримталж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

## **ГУРАВ.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ИРГЭДИЙН ОРОЛЦОО:**

### **3.1. Төрийн албан хаагчид, төрийн үйлчилгээний шуурхай байдал:**

3.1.1. Төрийн албанаас эрт тэтгэвэрт гарч буй иргэд жижиг, дунд, бичил бизнесийн салбарт ажиллах, баялаг бүтээх боломжийг бүрдүүлнэ.

3.1.2. Сумандаа засаглалын зөв механизмыг бүрдүүлж, мөчлөг дагасан сонгуулийн бодлогоос татгалзан, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулж, төрийн албаны мерит зарчмыг баримтална.

3.1.3. Сумандаа засаглалын эрүүл орчныг бий болгож, бизнес эрхлэгчдийн итгэл, сонирхол татах орчныг бүрдүүлэх бодлого баримтална.

3.1.4. Төрийн үйлчилгээнд хувийн хэвшил, иргэний оролцоот үнэлгээ, хариуцлагыг сайжруулна.

3.1.5. Интернэтийн сүлжээг хүртээмжтэй болгож, төрийн үйлчилгээг цаг алдалгүй, шуурхай авах боломжийг бүрдүүлнэ.



### **ДӨРӨВ. АЮУЛГҮЙ ТАЙВАН ОРЧИН:**

- 4.1. Гамшиг, аюулаас хамгаалах үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагын болон орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 4.2. Авлигын эсрэг шүгэл үлээгчийг хамгаалах, дэмжих орчныг бүрдүүлнэ.
- 4.3. Сумын эрсдэл бүхий газруудыг камержуулж, цагдаагийн байгууллагатай шууд, хялбар байдлаар холбогдох нөхцөлийг бүрдүүлнэ.
- 4.4. Инженерийн шугам сүлжээний аюулгүй байдлын стандартыг хангуулна.
- 4.5. Иргэн бүрийн аюулгүй байдлаа хангахад хэрэгцээтэй мэдээллийг нийгэмд түгээж, иргэдийн оролцоог дэмжинэ.

### **ТАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ:**

- 5.1. Сумын нутаг дэвсгэрийн цөлжилтийг сааруулах, хамгаалалтын зурвасыг нэмэгдүүлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.
- 5.2. Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлээр нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлнэ.
- 5.3. Ус, агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах цогц дэд хөтөлбөр боловсруулна.
- 5.4. Сумын иргэдийн амьдралд сайнаар нөлөөлөх, жуулчдад чанартай үйлчилгээ үзүүлэх, аялал жуулчлалын дэд бүтцэд хийх гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж, хамтран ажиллана.
- 5.5. Аялал жуулчлалын салбарт ажиллах хүчний ур чадварыг хөгжүүлэхэд анхаарч, сургалтад хамруулах асуудлыг бодлогоор дэмжинэ.
- 5.6. Аялал, жуулчлалын эрэлтийг нэмэгдүүлэх, эргэлтийг нь сайжруулах зорилго бүхий арга хэмжээг зохион байгуулна.


### **ЗУРГАА. ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ШУДАРГА ЁС**

- 6.1. Нас, хүйс, хөгжлийн ялгаа, бэлгийн чиг баримжаа гэх мэт аливаа төрлийн ялгаварлал, дарамт, хүчирхийллийг гэр бүлийн орчин, ажлын байр, олон нийтийн бүх орчинд таслан зогсооход чиглэсэн арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 6.2. Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүл, сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хангах, ажлын байран дахь бэлгийн дарамттай тэмцэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 6.3. Гамшиг, аюулаас хамгаалах мэргэжлийн байгууллага болон орон нутгийн иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлж, хамтарч ажиллана.
- 6.4. Нутгийн удирдлагын байгууллагын ил тод, нээлттэй байдал, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор цахим ИТХ-ыг жилд 1-ээс доошгүй удаа хийнэ.
- 6.5. Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай, үр дүнтэй хүргэнэ.

6.6. Иргэддээ итгэж, анхан шатны нэгж дээрээ асуудлаа шийдвэрлэх зарчимд тулгуурласан нутгийн удирдлагыг бэхжүүлнэ.

6.7. Төсвийн зарцуулалтад тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлнэ.

6.8. Суманд хэрэгжүүлэх аливаа төсөл, хөтөлбөр, тендерийн сонгон шалгаруулалтыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, олон нийтийн оролцоотой ил тод, нээлттэй болгоно.



## **ЖАВХЛАНТ СУМЫН АРДЧИЛСАН НАМ**